



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/115

Булган сум

Биеийн тамирын багш, дасгалжуулагчийн хувцас, материалын зардалд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 16 сум 1 тосгоны ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш, дасгалжуулагчийн хувцас, материалын зардалд 7,820,000 (долоон сая найман зуун хорин мянга) төгрөгийг зарцуулсугай.


2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж, “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 01-ны өдрийн А/М.С. дугаар
захирамжийн хавсралт



БИЕЙН ТАМИРЫН БАГШ, ДАСГАЛЖУУЛАГЧИЙН ХУВЦАС,
МАТЕРИАЛЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Биеийн тамирын хослол	68 багш	115,000	7,820,000
Нийт дүн			7,820,000	